



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/430

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит XIII хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 3061437 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай хуулийн этгээд “Мондэвш” ХХК (РД:2705397)-ийн хүсэлтийн дагуу Мөрөн сумын 7 дугаар баг Шинэ мөрөн худалдааны төвийн зүүн хажуу талд байршилтай зоорины зориулалттай 203м2 газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээд “Мондэвш” ХХК (РД:2705397)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

671 0010052